



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/528

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 94 дүгээр дүгнэлтийн дагуу Сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын /Өвөрхангай, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан сум/ ажлын 1 дүгээр багц Хужирт сумын ерөнхий боловсролын сургуулийн засварыг 89900000 (наян есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр Хүүшийн гэгээ ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгжид санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөх, хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар /Н.Ганболд/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100934